НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуйтайлан

Аудитын код: НТАГ-2026/181/НА-СТА-ТШЗ



| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.audit.mn<br><br>Улаанбаатар хот<br>2026 он | Дарга, тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал<br>Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn<br>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр<br>Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Д.Отгонбаяр<br>Утас: 325093 Цахим хаяг: otgonbayard@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: М.Ундармаа<br>Утас: 325093 Цахим хаяг: undarmaam@audit.gov.mn |



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ....................................................................... 2

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ................................... 4

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ..................................................................................... 13

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ............................................ 16

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026 . 02. 25 № 389
танай ______ -ны № ______ -т

НИЙСЛЭЛИЙН СҮХБААТАР ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА БӨГӨӨД АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА Ц.ОСОРВААНЬ ТАНАА

## Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

## Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

## Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зардалд 2,396.2 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 2,163.6 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнээс: Шүүх, цагдаа, шүүхийн шинжилгээний хэлтэс, сургуулиудад машин, тоног төхөөрөмж худалдан авахад 570.4 сая төгрөгийг зарцуулсан байна. Мөн ажилтан, албан хаагчдад 160.0 сая төгрөгийн буцалтгүй тусламжийг олгосон байна.

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

## Аудитын гол асуудал

Тайлант онд 8,225.5 сая төгрөгийн төсөв батлуулж, үйл ажиллагаандаа 5,657.9 сая төгрөгийн төсөв зарцуулсан нь өмнөх онтой харьцуулахад 29.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

1426050573
C:\Users\narangua.i\Desktop\Бичиг хэрэг 2026\2026\word\ywsan bichig\Dugnelt 2026.docx

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудал**

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03/19 дүгээр тогтоолоор "Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-г 3 бүлэг 159 заалттай төлөвлөж батлснаас 98.0 хувийн хэрэгжилттэй тайлагнасан байна.

Тайлант онд хэвлэл мэдээллийн 5 байгууллагатай гэрээ байгуулж, байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулахад 45.6 сая төгрөгийг зарцуулжээ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

C:\Users\narangua.j\Desktop\Бичиг хэрэг 2026\2026\word\ywsan bichig\Dugnelt 2026.docx

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Эхний үлдэгдэл | 2. Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | 1.1 ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 227,325,220.82 | 292,253,518.82 |
| 33 | 1.1.3 АВЛАГА | 691,620.81 | 64,152,951.81 |
| 33100 | 1.1.3.01 Ажиллагчидтай холбогдсон авлага | 0 | 776,771.81 |
| 33300 | 1.1.3.03 Татаас, санхүүжилтийн авлага | 0 | 20,676,180.00 |
| 33500 | 1.1.3.07 Бусад авлага | 691,620.81 | 42,700,000.00 |
| 33510 | 1.1.3.07.01 Байгууллагаас авах авлага | 691,620.81 | 42,700,000.00 |
| 35 | 1.1.5 БАРАА МАТЕРИАЛ | 226,633,600.01 | 228,100,567.01 |
| 35400 | 1.1.5.04 Хангамжийн материал | 226,633,600.01 | 228,100,567.01 |
| 35410 | 1.1.5.04.01 Бичиг хэргийн материал | 7,437,130.00 | 6,753,710.00 |
| 35420 | 1.1.5.04.02 Аж ахуйн материал | 50,838,073.01 | 57,360,467.01 |
| 35430 | 1.1.5.04.03 Сэлбэг хэрэгсэл | 5,340,000.00 | 5,070,000.00 |
| 35440 | 1.1.5.04.04 Түлш, шатах тослох материал | 11,238,000.00 | 3,730,000.00 |
| 35460 | 1.1.5.04.06 Хүнсний материал | 203,880.00 | 189,003.00 |
| 35470 | 1.1.5.04.07 Бусад хангамжийн материал | 151,576,517.00 | 154,997,387.00 |
| 2 | 1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 670,720,094.48 | 568,690,490.68 |
| 39 | 1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 670,720,094.48 | 568,690,490.68 |
| 39200 | 1.2.2.02 Биет хөрөнгө | 670,720,094.48 | 568,690,490.68 |
| 39203 | 1.2.2.02.03 Авто-тээврийн хэрэгсэл | 183,000,000.00 | 183,000,000.00 |
| 39204 | 1.2.2.02.04 Хуримтлагдсан элэгдэл | -39,468,750.00 | -57,768,750.00 |
| 39205 | 1.2.2.02.05 Машин тоног төхөөрөмж(компьютер) | 702,012,861.10 | 744,969,161.10 |
| 39206 | 1.2.2.02.06 Хуримтлагдсан элэгдэл | -216,076,365.93 | -344,876,950.25 |
| 39207 | 1.2.2.02.07 Тавилга, аж ахуйн эд хогшил | 111,755,987.97 | 119,255,987.97 |
| 39208 | 1.2.2.02.08 Хуримтлагдсан элэгдэл | -70,503,638.66 | -75,888,958.14 |
| 39301 | 1.2.2.03.01 Программ хангамж | 335,000.00 | 335,000.00 |
| 39302 | 1.2.2.03.02 Хуримтлагдсан элэгдэл | -335,000.00 | -335,000.00 |
| 3 | 1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2 | 898,045,315.30 | 860,944,009.50 |
| 4 | 2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР | 59,000,000.00 | 7,972,328.00 |
| 41 | 2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 59,000,000.00 | 7,972,328.00 |
| 41300 | 2.1.1.03 Өглөг | 59,000,000.00 | 7,972,328.00 |
| 41360 | 2.1.1.03.06 Бусад өглөг | 59,000,000.00 | 7,972,328.00 |
| 41361 | 2.1.1.03.06.01 Байгууллагад төлөх өглөг | 59,000,000.00 | 7,972,328.00 |
| 5 | 2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 839,045,315.30 | 852,971,681.50 |
| 51 | 2.2.1 Засгийн газрын хувь оролцоо | 839,045,315.30 | 852,971,681.50 |
| 51100 | 2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал | 44,964,769.50 | 44,964,769.50 |
| 511002 | 2.2.1.01.02 Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 44,964,769.50 | 44,964,769.50 |
| 51200 | 2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн | 794,080,545.80 | 808,006,912.00 |
| 51210 | 2.2.1.08.01 Өмнөх үеийн үр дүн | 806,024,608.56 | 794,080,545.80 |
| 51220 | 2.2.1.08.02 Тайлант үеийн үр дүн | -11,944,062.76 | 13,926,366.20 |
| 6 | 2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5 | 898,045,315.30 | 860,944,009.50 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Өмнөх он | 2. Тайлант он |
|---|---|---|---|
| I | 1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 9,016,077,867.80 | 5,860,600,596.61 |
| 12 | 1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 938,000.00 | 5,860,600,596.61 |
| 120 | 1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого | 938,000.00 | 0 |
| 120004 | 1.1.1.04.1.04 Төсөв байгууллагын өөрийн орлого | 938,000.00 | 0 |
| 1200042 | 1.1.1.04.1.04.02 Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 938,000.00 | 0 |
| 122 | 1.1.1.04.3 Тусламжийн орлого | 0 | 5,860,600,596.61 |
| 1221 | 1.1.1.04.3.01 Хандив тусламж /дотоод/ | 0 | 5,860,600,596.61 |
| 12211 | 1.1.1.04.3.01.01 Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | 0 | 5,657,894,356.61 |
| 122111 | 1.1.1.04.3.01.01.1 Урсгал санхүүжилтийн орлого | 0 | 5,657,894,356.61 |
| 12213 | 1.1.1.04.3.01.03 Нэмэлт санхүүжилтийн орлого | 0 | 202,706,240.00 |
| 122134 | 1.1.1.04.3.01.03.3 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0 | 200,000,000.00 |
| 122135 | 1.1.1.04.3.01.03.4 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 0 | 2,706,240.00 |
| 13 | 1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 9,015,139,867.80 | 0 |
| 1311 | 1.1.1.05.2 Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,022,149,920.00 | 0 |
| 131104 | 1.1.1.05.2.03 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 711,000,000.00 | 0 |
| 131105 | 1.1.1.05.2.04 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 311,149,920.00 | 0 |
| 1320 | 1.1.1.05.3 Орон нутгийн төсвөөс санхүүжих | 7,992,989,947.80 | 0 |
| 132001 | 1.1.1.05.3.01 Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 7,992,989,947.80 | 0 |
| II | 1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 9,028,021,930.56 | 5,846,674,230.41 |
| 21 | 1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ | 9,028,021,930.56 | 5,846,674,230.41 |
| 210 | 1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 8,211,810,462.29 | 5,609,522,720.41 |
| 2101 | 1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,621,165,156.44 | 1,646,335,144.85 |
| 210101 | 1.1.2.01.1.01.01 Үндсэн цалин | 933,775,953.66 | 841,270,821.16 |
| 210102 | 1.1.2.01.1.01.02 Нэмэгдэл | 266,270,818.91 | 411,467,913.14 |
| 210103 | 1.1.2.01.1.01.03 Унаа хоолны хөнгөлөлт | 267,966,065.79 | 345,260,773.19 |
| 210104 | 1.1.2.01.1.01.04 Урамшуулал | 117,439,423.85 | 48,335,637.36 |
| 210105 | 1.1.2.01.1.01.05 Гэрээт ажлын хөлс | 35,712,894.23 | 0 |
| 2102 | 1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 206,741,152.70 | 207,149,392.66 |
| 210201 | 1.1.2.01.1.02.01 Тэтгэврийн даатгалын зардал | 160,749,901.58 | 163,375,415.53 |
| 210202 | 1.1.2.01.1.02.02 Тэтгэмжийн даатгалын зардал | 14,654,653.74 | 14,302,162.61 |
| 210203 | 1.1.2.01.1.02.03 ҮОМШӨ-ний даатгалын зардал | 4,346,334.20 | 3,597,207.18 |
| 210204 | 1.1.2.01.1.02.04 Ажилгүйдлийн даатгалын зардал | 13,506,354.81 | 8,634,702.49 |

| | | | |
|---|---|---|---|
| 210205 | 1.1.2.01.1.02.05 Эрүүл мэндийн даатгалын зардал | 13,483,908.37 | 17,239,904.85 |
| 2104 | 1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал | 200,984,794.83 | 166,001,428.20 |
| 210401 | 1.1.2.01.1.04.01 Бичиг хэрэг | 30,896,000.00 | 36,950,810.00 |
| 210402 | 1.1.2.01.1.04.02 Тээвэр, шатахуун | 132,583,340.00 | 115,441,890.00 |
| 210403 | 1.1.2.01.1.04.03 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,266,036.83 | 4,483,178.20 |
| 210404 | 1.1.2.01.1.04.04 Ном, хэвлэл | 0 | 2,200,000.00 |
| 210406 | 1.1.2.01.1.04.06 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 33,239,418.00 | 6,925,550.00 |
| 2106 | 1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал | 8,946,900.00 | 24,690,000.00 |
| 210601 | 1.1.2.01.1.06.01 Багаж, техник, хэрэгсэл | 349,900.00 | 0 |
| 210604 | 1.1.2.01.1.06.04 Урсгал засвар | 8,597,000.00 | 24,690,000.00 |
| 2107 | 1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал | 518,926,148.16 | 245,258,759.00 |
| 210701 | 1.1.2.01.1.07.01 Гадаад албан томилолт | 444,230,865.46 | 152,836,184.00 |
| 210702 | 1.1.2.01.1.07.02 Дотоод албан томилолт | 14,238,445.00 | 0 |
| 210703 | 1.1.2.01.1.07.03 Зочин төлөөлөгч хүлээн авах | 60,456,837.70 | 92,422,575.00 |
| 2108 | 1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,266,243,796.28 | 3,051,706,041.90 |
| 210801 | 1.1.2.01.1.08.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,263,421,929.28 | 3,044,876,961.90 |
| 210803 | 1.1.2.01.1.08.03 Даатгалын үйлчилгээ | 1,439,100.00 | 2,500,000.00 |
| 210804 | 1.1.2.01.1.08.04 Тээврийн хэрэгслийн татвар | 284,767.00 | 462,080.00 |
| 210805 | 1.1.2.01.1.08.05 Тээврийн хэрэгслийн оношилгоо | 22,000.00 | 0 |
| 210806 | 1.1.2.01.1.08.06 Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,076,000.00 | 3,867,000.00 |
| 2109 | 1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал | 388,802,513.88 | 268,381,953.80 |
| 210901 | 1.1.2.01.1.09.01 Бараа үйлчилгээний бусад зардал | 237,029,812.50 | 97,896,050.00 |
| 210902 | 1.1.2.01.1.09.02 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 32,253,000.00 | 18,000,000.00 |
| 210903 | 1.1.2.01.1.09.03 Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 119,519,701.38 | 152,485,903.80 |
| 213 | 1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 816,211,468.27 | 237,151,510.00 |
| 2131 | 1.1.2.01.4.01 Засгийн газрын урсгал шилжүүлэг | 1,575,188.27 | 2,706,240.00 |
| 21311 | 1.1.2.01.4.01.01 Засгийн газрын дотоод шилжүүлэг | 1,575,188.27 | 2,706,240.00 |
| 213112 | 1.1.2.01.4.01.01.2 Төсвийн байгууллагаас харьяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | 0 | 2,706,240.00 |
| 2131123 | 1.1.2.01.4.01.01.2.3 Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал | 0 | 2,706,240.00 |
| 213101 | 1.1.2.01.4.01.01.9 Бусад засгийн газрын дотоод шилжүүлэг | 1,575,188.27 | 0 |
| 2132 | 1.1.2.01.4.02 Бусад урсгал шилжүүлэг | 812,534,580.00 | 234,445,270.00 |
| 213205 | 1.1.2.01.4.02.04 Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 567,470,000.00 | 48,750,000.00 |
| 213209 | 1.1.2.01.4.02.08 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 245,064,580.00 | 185,695,270.00 |
| 2134 | 1.1.2.01.4.04 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 2,101,700.00 | 0 |
| 213403 | 1.1.2.01.4.04.03 Төвлөрүүлэх шилжүүлэг | 938,000.00 | 0 |

| | | | |
|---|---|---|---|
| 213405 | 1.1.2.01.4.04.05 Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 1,163,700.00 | 0 |
| III | 1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | -11,944,062.76 | 13,926,366.20 |
| VI | 1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII) | -11,944,062.76 | 13,926,366.20 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *\/төгрөгөөр/*

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Өмнөх он | 2. Тайлант он |
|---|---|---|---|
| I | 1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 9,016,077,867.80 | 5,860,600,596.61 |
| 12 | 1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 938,000.00 | 5,860,600,596.61 |
| 120 | 1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого | 938,000.00 | 0 |
| 120004 | 1.1.1.1.04.1.04 Төсөв байгууллагын өөрийн орлого | 938,000.00 | 0 |
| 1200042 | 1.1.1.1.04.1.04.02 Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 938,000.00 | 0 |
| 122 | 1.1.1.1.04.3 Тусламжийн орлого | 0 | 5,860,600,596.61 |
| 1221 | 1.1.1.1.04.3.01 Хандив тусламж /дотоод/ | 0 | 5,860,600,596.61 |
| 12211 | 1.1.1.1.04.3.01.01 Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | 0 | 5,657,894,356.61 |
| 122111 | 1.1.1.1.04.3.01.01.1 Урсгал санхүүжилтийн орлого | 0 | 5,657,894,356.61 |
| 12213 | 1.1.1.1.04.3.01.03 Нэмэлт санхүүжилтийн орлого | 0 | 202,706,240.00 |
| 122134 | 1.1.1.1.04.3.01.03.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0 | 200,000,000.00 |
| 122135 | 1.1.1.1.04.3.01.03.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 0 | 2,706,240.00 |
| 13 | 1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 9,015,139,867.80 | 0 |
| 1311 | 1.1.1.1.05.2 Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,022,149,920.00 | 0 |
| 131104 | 1.1.1.1.05.2.04 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 711,000,000.00 | 0 |
| 131105 | 1.1.1.1.05.2.05 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 311,149,920.00 | 0 |
| 1320 | 1.1.1.1.05.3 Орон нутгийн төсвөөс санхүүжих | 7,992,989,947.80 | 0 |
| 132001 | 1.1.1.1.05.3.01 Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 7,992,989,947.80 | 0 |
| II | 1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 8,561,812,767.80 | 5,810,144,296.61 |
| 21 | 1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ | 8,561,812,767.80 | 5,810,144,296.61 |
| 210 | 1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 7,739,666,487.80 | 5,547,197,806.61 |

| | | | |
|---|---|---|---|
| 2101 | 1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,621,643,581.13 | 1,644,947,967.85 |
| 210101 | 1.1.1.2.01.1.01.01 Үндсэн цалин | 910,249,583.89 | 857,319,896.97 |
| 210102 | 1.1.1.2.01.1.01.02 Нэмэгдэл | 267,416,713.65 | 394,105,880.00 |
| 210103 | 1.1.1.2.01.1.01.03 Унаа хоолны хөнгөлөлт | 268,604,814.99 | 347,525,502.33 |
| 210104 | 1.1.1.2.01.1.01.04 Урамшуулал | 140,358,918.91 | 45,996,688.55 |
| 210105 | 1.1.1.2.01.1.01.05 Гэрээт ажлын хөлс | 35,013,549.69 | 0 |
| 2102 | 1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 201,850,267.58 | 207,149,392.66 |
| 210201 | 1.1.1.2.01.1.02.01 Тэтгэврийн даатгалын зардал | 158,791,037.91 | 163,375,415.53 |
| 210202 | 1.1.1.2.01.1.02.02 Тэтгэмжийн даатгалын зардал | 14,618,394.74 | 14,302,162.61 |
| 210203 | 1.1.1.2.01.1.02.03 ҮОМШӨ-ний даатгалын зардал | 2,543,320.08 | 3,597,207.18 |
| 210204 | 1.1.1.2.01.1.02.04 Ажилгүйдлийн даатгалын зардал | 11,733,040.69 | 8,634,702.49 |
| 210205 | 1.1.1.2.01.1.02.05 Эрүүл мэндийн даатгалын зардал | 14,164,474.16 | 17,239,904.85 |
| 2104 | 1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал | 220,305,448.83 | 144,788,149.20 |
| 210401 | 1.1.1.2.01.1.04.01 Бичиг хэрэг | 24,995,330.00 | 28,593,340.00 |
| 210402 | 1.1.1.2.01.1.04.02 Тээвэр, шатахуун | 55,196,340.00 | 37,803,110.00 |
| 210403 | 1.1.1.2.01.1.04.03 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,167,636.83 | 4,636,078.20 |
| 210404 | 1.1.1.2.01.1.04.04 Ном, хэвлэл | 119,950,000.00 | 51,821,800.00 |
| 210406 | 1.1.1.2.01.1.04.06 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 15,996,142.00 | 21,933,821.00 |
| 2106 | 1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал | 38,440,700.00 | 33,229,800.00 |
| 210601 | 1.1.1.2.01.1.06.01 Багаж, техник, хэрэгсэл | 21,971,700.00 | 794,800.00 |
| 210604 | 1.1.1.2.01.1.06.04 Урсгал засвар | 16,469,000.00 | 32,435,000.00 |
| 2107 | 1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал | 516,967,253.60 | 261,295,089.90 |
| 210701 | 1.1.1.2.01.1.07.01 Гадаад албан томилолт | 447,330,865.46 | 165,791,114.90 |
| 210702 | 1.1.1.2.01.1.07.02 Дотоод албан томилолт | 15,128,445.00 | 0 |
| 210703 | 1.1.1.2.01.1.07.03 Зочин төлөөлөгч хүлээн авах | 54,507,943.14 | 95,503,975.00 |
| 2108 | 1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,124,802,616.52 | 3,096,884,082.00 |
| 210801 | 1.1.1.2.01.1.08.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,121,980,749.52 | 3,090,839,554.00 |
| 210803 | 1.1.1.2.01.1.08.03 Даатгалын үйлчилгээ | 1,439,100.00 | 2,500,000.00 |
| 210804 | 1.1.1.2.01.1.08.04 Тээврийн хэрэгслийн татвар | 284,767.00 | 347,528.00 |
| 210805 | 1.1.1.2.01.1.08.05 Тээврийн хэрэгслийн оношилгоо | 22,000.00 | 0 |
| 210806 | 1.1.1.2.01.1.08.06 Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,076,000.00 | 3,197,000.00 |
| 2109 | 1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал | 1,015,656,620.14 | 158,903,325.00 |
| 210901 | 1.1.1.2.01.1.09.01 Бараа үйлчилгээний бусад зардал | 904,803,120.14 | 133,228,325.00 |
| 210902 | 1.1.1.2.01.1.09.02 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 110,853,500.00 | 25,675,000.00 |
| 213 | 1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 822,146,280.00 | 262,946,490.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2131 | 1.1.1.2.01.4.01 Засгийн газрын урсгал шилжүүлэг | 0 | 23,382,420.00 |
| 21311 | 1.1.1.2.01.4.01.01 Засгийн газрын дотоод шилжүүлэг | 0 | 23,382,420.00 |
| 213112 | 1.1.1.2.01.4.01.01.2 Төсвийн байгууллагаас харьяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | 0 | 23,382,420.00 |
| 2131123 | 1.1.1.2.01.4.01.01.2.3 Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал | 0 | 2,706,240.00 |
| 2131126 | 1.1.1.2.01.4.01.01.2.6 Нэмэлт санхүүжилтийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | 0 | 20,676,180.00 |
| 2132 | 1.1.1.2.01.4.02 Бусад урсгал шилжүүлэг | 820,044,580.00 | 239,564,070.00 |
| 213205 | 1.1.1.2.01.4.02.04 Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 575,970,000.00 | 53,868,800.00 |
| 213209 | 1.1.1.2.01.4.02.08 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 244,074,580.00 | 185,695,270.00 |
| 2134 | 1.1.1.2.01.4.04 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 2,101,700.00 | 0 |
| 213403 | 1.1.1.2.01.4.04.03 Төвлөрүүлэх шилжүүлэг | 938,000.00 | 0 |
| 213405 | 1.1.1.2.01.4.04.05 Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 1,163,700.00 | 0 |
| III | 1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 454,265,100.00 | 50,456,300.00 |
| V | 1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 454,265,100.00 | 50,456,300.00 |
| 22 | 1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 454,265,100.00 | 50,456,300.00 |
| 2200 | 1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр | 454,265,100.00 | 50,456,300.00 |
| 225106 | 1.1.2.2.01.1.06 Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 454,265,100.00 | 50,456,300.00 |
| VI | 1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -454,265,100.00 | -50,456,300.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *\/төгрөгөөр/*

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1.1 Засгийн газрын оруулсан капитал | 1.2 Дахин үнэлгээний нөөц | 1.3 Хуримтлагдсан үр дүн | 1.4 Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 44,964,769.50 | 1,290,344.75 | 804,734,263.81 | 850,989,378.06 |
| 2 | 1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0 | 0 | 1,290,344.75 | 1,290,344.75 |
| 3 | 1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 44,964,769.50 | 1,290,344.75 | 806,024,608.56 | 852,279,722.81 |
| 4 | 1.1.1.1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0 | -1,290,344.75 | 0 | -1,290,344.75 |
| 9 | 1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн | 0 | 0 | -11,944,062.76 | -11,944,062.76 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 10 | 1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 44,964,769.50 | 0 | 794,080,545.80 | 839,045,315.30 |
| 11 | 1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 44,964,769.50 | 0 | 794,080,545.80 | 839,045,315.30 |
| 13 | 1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 44,964,769.50 | 0 | 794,080,545.80 | 839,045,315.30 |
| 19 | 1.7 Тайлант үеийн үр дүн | 0 | 0 | 13,926,366.20 | 13,926,366.20 |
| 20 | 1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 44,964,769.50 | 0 | 808,006,912.00 | 852,971,681.50 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *\/төгрөгөөр/*

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Төлөвлөгөө | 2. Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | 3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 8,225,593,200.00 | 5,657,894,356.61 | 2,567,698,843.39 | 68.8% |
| 12 | 3.1.01.1.2 Татварын бус орлого | 8,225,593,200.00 | 5,657,894,356.61 | 2,567,698,843.39 | 68.8% |
| 122 | 3.1.01.1.2.3 Тусламжийн орлого | 8,225,593,200.00 | 5,657,894,356.61 | 2,567,698,843.39 | 68.8% |
| 122005 | 3.1.01.1.2.3.5 Төсвөөс санхүүжих | 8,225,593,200.00 | 5,657,894,356.61 | 2,567,698,843.39 | 68.8% |
| II | 3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 8,225,593,200.00 | 5,657,894,356.61 | 2,567,698,843.39 | 68.8% |
| 21 | 3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ | 8,225,593,200.00 | 5,657,894,356.61 | 2,567,698,843.39 | 68.8% |
| 210 | 3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 7,854,593,200.00 | 5,458,330,286.61 | 2,396,262,913.39 | 69.5% |
| 2101 | 3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,864,034,700.00 | 1,644,947,967.85 | 219,086,732.15 | 88.2% |
| 210101 | 3.1.01.2.1.1.1.01 Үндсэн цалин | 994,395,600.00 | 857,319,896.97 | 137,075,703.03 | 86.2% |
| 210102 | 3.1.01.2.1.1.1.02 Нэмэгдэл | 257,537,500.00 | 394,105,880.00 | -136,568,380.00 | 153.0% |
| 210103 | 3.1.01.2.1.1.1.03 Унаа хоолны хөнгөлөлт | 502,851,800.00 | 347,525,502.33 | 155,326,297.67 | 69.1% |
| 210104 | 3.1.01.2.1.1.1.04 Урамшуулал | 109,249,800.00 | 45,996,688.55 | 63,253,111.45 | 42.1% |
| 2102 | 3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 233,004,500.00 | 207,149,392.66 | 25,855,107.34 | 88.9% |
| 210201 | 3.1.01.2.1.1.2.01 Тэтгэврийн даатгал | 177,083,300.00 | 163,375,415.53 | 13,707,884.47 | 92.3% |
| 210202 | 3.1.01.2.1.1.2.02 Тэтгэмжийн даатгал | 18,640,400.00 | 14,302,162.61 | 4,338,237.39 | 76.7% |
| 210203 | 3.1.01.2.1.1.2.03 ҮОМШӨ-ний даатгал | 3,728,100.00 | 3,597,207.18 | 130,892.82 | 96.5% |
| 210204 | 3.1.01.2.1.1.2.04 Ажилгүйдлийн даатгал | 14,912,300.00 | 8,634,702.49 | 6,277,597.51 | 57.9% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210205 | 3.1.01.2.1.1.2.05 Эрүүл мэндийн даатгал | 18,640,400.00 | 17,239,904.85 | 1,400,495.15 | 92.5% |
| 2104 | 3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал | 221,160,000.00 | 144,788,149.20 | 76,371,850.80 | 65.5% |
| 210401 | 3.1.01.2.1.1.4.01 Бичиг хэрэг | 28,860,000.00 | 28,593,340.00 | 266,660.00 | 99.1% |
| 210402 | 3.1.01.2.1.1.4.02 Тээвэр, шатахуун | 56,800,000.00 | 37,803,110.00 | 18,996,890.00 | 66.6% |
| 210403 | 3.1.01.2.1.1.4.03 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,500,000.00 | 4,636,078.20 | 863,921.80 | 84.3% |
| 210404 | 3.1.01.2.1.1.4.04 Ном, хэвлэл | 100,000,000.00 | 51,821,800.00 | 48,178,200.00 | 51.8% |
| 210406 | 3.1.01.2.1.1.4.06 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 30,000,000.00 | 21,933,821.00 | 8,066,179.00 | 73.1% |
| 2106 | 3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал | 146,500,000.00 | 76,186,100.00 | 70,313,900.00 | 52.0% |
| 210601 | 3.1.01.2.1.1.6.01 Багаж, техник, хэрэгсэл | 71,500,000.00 | 43,751,100.00 | 27,748,900.00 | 61.2% |
| 210602 | 3.1.01.2.1.1.6.02 Тавилга | 10,000,000.00 | 0 | 10,000,000.00 | 0.0% |
| 210604 | 3.1.01.2.1.1.6.04 Урсгал засвар | 65,000,000.00 | 32,435,000.00 | 32,565,000.00 | 49.9% |
| 2107 | 3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал | 382,500,000.00 | 261,295,089.90 | 121,204,910.10 | 68.3% |
| 210701 | 3.1.01.2.1.1.7.01 Гадаад албан томилолт | 222,500,000.00 | 165,791,114.90 | 56,708,885.10 | 74.5% |
| 210702 | 3.1.01.2.1.1.7.02 Дотоод албан томилолт | 25,000,000.00 | 0 | 25,000,000.00 | 0.0% |
| 210703 | 3.1.01.2.1.1.7.03 Зочин төлөөлөгч хүлээн авах | 135,000,000.00 | 95,503,975.00 | 39,496,025.00 | 70.7% |
| 2108 | 3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,779,894,000.00 | 2,965,060,262.00 | 1,814,833,738.00 | 62.0% |
| 210801 | 3.1.01.2.1.1.8.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,746,444,000.00 | 2,959,015,734.00 | 1,787,428,266.00 | 62.3% |
| 210803 | 3.1.01.2.1.1.8.03 Даатгалын үйлчилгээ | 2,500,000.00 | 2,500,000.00 | 0.00 | 100.0% |
| 210804 | 3.1.01.2.1.1.8.04 Тээврийн хэрэгслийн татвар | 350,000.00 | 347,528.00 | 2,472.00 | 99.3% |
| 210805 | 3.1.01.2.1.1.8.05 Тээврийн хэрэгслийн оношилгоо | 100,000.00 | 0 | 100,000.00 | 0.0% |
| 210806 | 3.1.01.2.1.1.8.06 Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 30,500,000.00 | 3,197,000.00 | 27,303,000.00 | 10.5% |
| 2109 | 3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал | 227,500,000.00 | 158,903,325.00 | 68,596,675.00 | 69.8% |
| 210901 | 3.1.01.2.1.1.9.01 Бараа үйлчилгээний бусад зардал | 157,500,000.00 | 133,228,325.00 | 24,271,675.00 | 84.6% |
| 210902 | 3.1.01.2.1.1.9.02 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 70,000,000.00 | 25,675,000.00 | 44,325,000.00 | 36.7% |
| 213 | 3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 371,000,000.00 | 199,564,070.00 | 171,435,930.00 | 53.8% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2131 | 3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг | 35,000,000.00 | 0 | 35,000,000.00 | 0.0% |
| 213101 | 3.1.01.2.1.4.1.01 Засгийн газрын дотоод шилжүүлэг | 35,000,000.00 | 0 | 35,000,000.00 | 0.0% |
| 2132 | 3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг | 336,000,000.00 | 199,564,070.00 | 136,435,930.00 | 59.4% |
| 213205 | 3.1.01.2.1.4.2.04 Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 15,000,000.00 | 13,868,800.00 | 1,131,200.00 | 92.5% |
| 213209 | 3.1.01.2.1.4.2.08 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 321,000,000.00 | 185,695,270.00 | 135,304,730.00 | 57.8% |
| 6 | 6 ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 159 | 107 | 52.00 | 67.3% |
| 61 | 6.1 БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | 0.00 | 100.0% |
| 610001 | 6.1.01 Төсвийн байгууллага | 1 | 1 | 0.00 | 100.0% |
| 62 | 6.2 АЖИЛЛАГСДЫН ТОО | 79 | 53 | 26.00 | 67.1% |
| 620001 | 6.2.01 Удирдах ажилтан | 5 | 5 | 0.00 | 100.0% |
| 620002 | 6.2.02 Гүйцэтгэх ажилтан | 65 | 46 | 19.00 | 70.8% |
| 620003 | 6.2.03 Үйлчлэх ажилтан | 8 | 2 | 6.00 | 25.0% |
| 620004 | 6.2.04 Гэрээт ажилтан | 1 | 0 | 1.00 | 0.0% |
| 65 | 6.5 ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 79 | 53 | 26.00 | 67.1% |
| 650001 | 6.5.01 Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 11 | 11 | 0.00 | 100.0% |
| 650009 | 6.5.09 Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 18 | 13 | 5.00 | 72.2% |
| 650010 | 6.5.10 Гэрээт ажилтан | 1 | 0 | 1.00 | 0.0% |
| 650011 | 6.5.11 Улс төрийн албан хаагч (УТ) | 49 | 29 | 20.00 | 59.2% |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Дансны нэр, төрөл | Тайлант он |
|---|---|---|
| 1 | 1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 202,706,240.00 |
| 12213 | 1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого | 202,706,240.00 |
| 350014 | 1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 202,706,240.00 |
| 350015 | 1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,706,240.00 |
| II | 1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 179,323,820.00 |
| 21 | 1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ | 179,323,820.00 |
| 210 | 1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 139,323,820.00 |
| 2108 | 1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 139,323,820.00 |
| 210801 | 1.1.1.2.1.1.8.1 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 139,323,820.00 |

| | | |
|---|---|---|
| 213 | 1.1.1.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 40,000,000.00 |
| 2132 | 1.1.1.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг | 40,000,000.00 |
| 213205 | 1.1.1.2.1.4.2.4 Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 40,000,000.00 |
| 4 | 1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | 23,382,420.00 |
| 5 | 1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | -23,382,420.00 |
| 6 | 1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | -23,382,420.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 88,989.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 49,200.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 39,789.7 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 3.1 Албан шаардлага

3.1.1 Худалдан авалт хийхдээ гэрээ байгуулаагүй, төсөвт өртгийг хувааж 38,800.0 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т *"Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно"*, Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоолтой нийцээгүй, санхүүгийн тайлагналын “*нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>*Шийдвэрлэсэн нь:*</u> Босго үнийн шаардлагыг мөрдөж ажиллаагүй шууд худалдан авалт хийсэн зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага өгөв.

3.1.2 Цагдаагийн албан хаагчдын нөхөн сэргээгдэх эмчилгээний зардал 10,400.0 мянган төгрөгийг байгууллагын төсвөөс төлсөн нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д *“хариуцлагатай байх”,* 6 дугаар зүйлийн 6.4.1-д *“төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*; 6.6.6-д *"тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх",* Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.7-д *"Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг хууль тогтоомжид зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно" гэж заасантай* нийцээгүй, санхүүгийн тайлагналын “*нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>*Шийдвэрлэсэн нь:*</u> Байгууллагын төсвөөс эмчилгээний зардал төлж төсвийг үр ашиггүй зарцуулсан зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага өгөв.

### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.2.1 Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой асуудал

<u>*Илрүүлэлт 1:*</u> Нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг тухайн байгууллагын үйл ажиллагаа болон холбогдох хууль, журмын шаардлагад нийцүүлэн шинэчлэн боловсруулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т *"Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана"* гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “*нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцүүлж, хууль эрх зүйн шаардлагыг бүрэн тусгасан, ойлгомжтой бүтэцтэй, хэрэгжүүлэхэд хялбар бодлогын баримт бичиг боловсруулах.

*Илрүүлэлт 2:* Эдийн засгийн ангилал зөрчиж 21,189.7 мянган төгрөгийн зардал гаргасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т *“үнэн зөв байх”*, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалын тавдугаар хавсралтын хоёрт *“урсгал зардлын ангилаллын тайлбар”*- тай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “*ангилал*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Эдийн засгийн ангиллын дагуу ажил гүйлгээг хийж байх.

3.2.2 Зардлын данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт 1:* Албан хаагчдын дунд SBD QUIZ-60 арга хэмжээг зохион байгуулж 18,600.0 мянган төгрөгийн төсвийг үрэлгэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д *“хариуцлагатай байх”,* 6 дугаар зүйлийн 6.4.1-д *“төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"* гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “*нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Тэмцээн арга хэмжээний зардал төлөвлөхгүй байж төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар зарцуулах.

**3.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 317,117.0 мянган төгрөгийн зөрчилд 700.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 304,312.0 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 12,105.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүллээ.

1. Томилолтоор ажилласан ажилтанд хоол унааны мөнгө 700.0 мянган төгрөгийг давхардуулан олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-*т "Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан томилолтоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориглоно"* гэж заасантай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Илүү олгосон хоол унааны мөнгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Гадаад албан томилолтоор ажиллах ажилтны 48,065.0 мянган төгрөгийн онгоцны тийзийг үндэсний агаарын тээвэрлэгчээс худалдан аваагүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т *"Энэ хуулийн 3.1-д заасан этгээд нэн тэргүүнд үндэсний агаарын тээвэрлэгчийг сонгож үйлчлүүлнэ"* гэж заасантай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Албан томилолтоор ажиллах ажилтны тийз захиалахдаа үндэсний агаарын тээвэрлэгчийг сонгоогүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага өгөв.

3. Сургалт, гарын авлага, хэвлэх үйлчилгээ, арга хэмжээг зохион байгуулж Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжтэй байгуулсан 221,438.0 мянган төгрөгийн гэрээг дүгнээгүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3-т *“хэвлэлийн захиалгын төлбөр”* гэж заасантай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээг дүгнэж ажиллаагүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага өгөв.

4. Тайлант онд шаардлагагүй 34,809.0 мянган төгрөгийн бараа материал их хэмжээгээр худалдан авч нөөцөлсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д *"Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх*" гэж заасантай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Хэрэгцээ шаардлагаас их хэмжээний бараа материал нөөцөлж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага өгөв.

4. Тайлант онд орон тоог 9 хувиар бууруулаагүй нь Монгол Улсын Их Хурлын 2025 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл”-д “*Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ”* гэж заасантай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Төрийн албан хаагчдын орон тоог чиг үүргийн давхардал, гүйцэтгэлд үндэслэн үе шаттайгаар 9 хувьд хүргэж бууруулах зөвлөмж өгөв.

5. Нийслэлийн засаг даргын захирамжаар нийслэлийн өвлийн спортын арга хэмжээнд 12,105.0 мянган төгрөгийн төсвийг үрэлгэн зарцуулсан*”* нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-д *“байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах”* гэж заасантай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Биеийн тамир, спортын арга хэмжээг төсвөөс санхүүжүүлэхгүй байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчил

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс: | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| СБД цагдаагийн албан хаагчдыг нөхөн сэргээгдэх эмчилгээний зардлыг байгууллагын төсвөөс төлсөн байна. | 1 | 10,400.0 | 1 | 10,400.0 | | |
| Төсөвт өртгийг хувааж шууд худалдан авалт хийсэн. | 1 | 38,800.0 | 1 | 38,800.0 | | |
| Эдийн засгийн ангилал зөрчиж зардал гаргасан. | 1 | 21,189.7 | | | 1 | 21,189.7 |
| Албан хаагчдын дунд асуулт хариултын тэмцээн зохион байгуулсан байна. | 1 | 18,600.0 | | | 1 | 18,600.0 |
| Нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг шинэчлэн боловсруулаагүй байна. | 1 | - | | | 1 | - |
| **Дүн** | **5** | **88,989.7** | **2** | **49,200.0** | **3** | **39,789.7** |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс: | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | | | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Томилолтоор ажилласан ажилтанд хоол унааны мөнгийг давхардуулан өгсөн. | 1 | 700.0 | 1 | 700.0 | | | | |
| Үндэсний агаарын тээвэрлэгчээс онгоцны тийзийг худалдан аваагүй. | 1 | 48,065.0 | | | 1 | 48,065.0 | | |
| Сургалт, гарын авлага , хэвлэх үйлчилгээ, арга хэмжээний гэрээг дүгнээгүй. | 1 | 221,438.0 | | | 1 | 221,438.0 | | |
| Тайлант онд шаардлагагүй бараа материал их хэмжээгээр худалдан авч нөөцөлсөн. | 1 | 34,809.0 | | | 1 | 34,809.0 | | |
| Тайлант онд орон тоог 9 хувиар бууруулаагүй. | 1 | - | | | | | 1 | - |
| Нийслэлийн өвлийн спортын арга хэмжээнд оролцож төсвийг үрэлгэн зарцуулсан. | 1 | 12,105.0 | | | | | 1 | 12,105.0 |
| **Дүн** | **6** | **317,117.0** | **1** | **700.0** | **3** | **304,312.0** | **2** | **12,105.0** |